



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 9/118

Улаанбаатар хот

Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 зүйлийн 66.1, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Журам батлах тухай" А/151 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус дүүргийн 11 дүгээр хороо, Нуурын 14 дүгээр гудамжны 284 тоот "Боркогийн найзууд" хүүхэд харах үйлчилгээний төвийн хүсэлт, хорооны Засаг даргын дүгнэлтийг үндэслэн тус төвийн Хүүхэд харагч Далхжавын Мөнхжаргал, Батжаргалын Отгондаваа нарт 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгосугай.

2.Хүүхэд харах үйлчилгээг стандарт шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, хүүхдийн эрхийг хангаж ажиллахыг Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Х.Азбаяр), хорооны Засаг дарга (Ч.Дархансоёмбо) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010335